МЭДЭЭ · 2022 оны 8-р сарын 14

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР Б.ЖАРГАЛСАЙХАН "ПРОКУРОРЫН АЛБАНЫ ӨДӨР"-ИЙН МЭНДЧИЛГЭЭ ДЭВШҮҮЛЛЭЭ



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ГАЗАР

МЭНДЧИЛГЭЭ

Төрийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг нэг мөр хангуулах, Үндсэн хуулиар тунхагласан хүний эрх, эрх чөлөө, төр нийтийн ашиг сонирхлыг хамгаалах, нийгмийн шударга ёсны баталгаа байх эрхэм зорилгоо нэр төртэйгөөр биелүүлж буй эрхэм прокурор, ажилтнууд болон прокурорын байгууллагад ажиллаж байсан ахмадууд Та бүхэндээ Монгол Улсад Прокурорын байгууллага үүсч байгуулагдсаны түүхт 92 жилийн ой, "Прокурорын албаны өдөр"-ийн баярын мэндийг дэвшүүлье.

Прокурорын албаны өдөр Та бидний хувьд төрийнхөө өмнө өргөсөн тангараг, түмнийхээ өмнө хүлээсэн үүргээ чин үнэнчээр биелүүлж, үнэнийг дэнслэх гэгээн үйлстэй албаараа бахархах эрхэм хүндэтгэлийн өдөр билээ.

Монгол Улсын Прокурорын байгууллагын түүхийг бичилцэж, бие сэтгэл, мэдлэг оюун, хөдөлмөр зүтгэлээ зориулан ажиллаж байсан ахмад буурлууд, үе үеийн прокурор, ажилтан Та бүхнээрээ бахархаж байна.

Та бүхэндээ болон Та бүхний гэр бүлд тэмдэглэлт албаны өдрийн мэндчилгээг дахин дэвшүүлж, чин сэтгэлийн талархал илэрхийлж, эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
ПРОКУРОР, ТӨРИЙН ХУУЛЬ
ЦААЗЫН ТЭРГҮҮН ЗӨВЛӨХ

БАНЗРАГЧИЙН ЖАРГАЛСАЙХАН

2022 оны 8 дугаар
сарын 14-ний өдөр

Улаанбаатар
хот

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/2298